

ЧИНГИС СУДЛАЛЫН ӨНӨӨГИЙН ЧИГ ХАНДЛАГА

Ж.Болдбаатар

Монгол Улсын Их Сургууль, Түүхийн судалгааны хүрээлэн

Jigjid_boldbaatar@yahoo.com

Өгүүллийн товч утга: Энэхүү өгүүлэлд 1990-ээд оноос хойш Чингис судлал бие даан хөгжиж, түүхийн судалгааны томоохон чиглэл болсныг баримт судалгаатайгаар нотлон өгүүлсэн байна. Дэлхий дахины болон Монголын түүхэнд Чингис хааны гүйцэтгэсэн үүргийг түүхчид янз бүрийн өнцгөөс үнэлж дүгнэж, олон асуудлаар нэгдмэл байр сууринд хүрч байгааг эл өгүүлэлд олон талаас нь авч үзжээ.

Түлхүүр үг: Түүхэн хүн судлал, Чингис хаан, байлдан дагуулал, эх сурвалж, түүхэн үүрэг, намтар судлал

Ардчилал, шинэтгэлийн жилүүдэд манай оронд түүхийг түүхэн хүн судлалын үүднээс бичиж туурвидаг францын дэг сургууль хүчтэй нэвтрэх болов. Үүний тодорхой илрэл бол намтар судлал эрчимтэй хөгжиж, 1990-ээд оноос хойш Монголын түүхээр туурвисан нэгэн сэдэвт зохиол, ном товхимолын 80 орчим хувь намтар судлалд холбогдож байна. Энэ бүхэн нь түүхийг гуйвуулж, эзэнгүйдүүлж, түүхэнд хоосон орон зай буюу “цагаан толбо” үлдээж байсныг даван туулахад мэдэгдэхүйц нөлөө үзүүлж байна.

Монголын түүхэн хүн судлалд хамгийн том байр суурь эзлэж байгаа түүхэн бие хүн бол үлэмжийн их Чингис хаан юм. Чингис хаан судлалыг явцуу утгаар нь зөвхөн түүний амьдрал, үйл ажиллагааг хамруулж, харин өргөн утгаар нь Чингис хаан, түүнийг залгамжлагчдын амьдрал, олон талт үйл ажиллагааг харуулсан судалгаа хэмээн тодорхойлж болно. Энэхүү илтгэлдээ би Чингис судлалыг өргөн утгаар нь бүх талыг хамран өгүүлэх боломжгүй нь хэнд ч ойлгомжтой учраас 1990-ээд оноос хойш гарсан бүтээлүүдийн зах зухаас тоймлон хэлэхийг хичээлээ.

Монголын түүхчдийн Чингис хааны талаар бичсэн нэгэн сэдэвт зохиол, ном бүтээлийг а. Чингис хааны амьдрал, үйл ажиллагааг судлахад шууд зориулсан судалгаа (Ш.Нацагдоржийн “Чингис хааны цадиг” (1991), Н.Ишжамц, Ж.Болдбаатар, И.Цоодол нарын “Хаадын сан”-гийн шугамаар гаргасан “Чингис” гурван боть, И.Дашнямын “Аугаа их Чингис хаан, түүний түүхэн гавъяа” (2006), Ж.Заанхүүгийн “Чингис хааны засан тохинуулах үйл ажиллагаа ба даяаршлын асуудал” (2006), зэрэг), б. Их Монгол улс, Эзэнт гүрний түүхийг судлах явцдаа Чингис хааны түүхэн үүргийн талаар сонирхолтой гаргалгаа хийсэн бүтээлүүд (Ш.Бирагийн “Их Монгол улсын түүх, үзэл суртлын зарим онцлог асуудлууд” (2006), Ч.Далайгийн “Их Монгол улс” (2006) зэрэг, в. Чингис хааны амьдрал, үйл ажиллагааны зарим тал хэсгийг авч үзсэн судалгаа (Ч.Баянжаргалын “Чингис хааны эдийн засгийн бодлого, өв уламжлал” (2005), Х.Шагдарын “Чингисийн байлдааны цадиг” (2005), Ж.Базарсүрэнгийн “Чингис хааны цэргийн зэр зэвсэг” (2000) зэрэг), г.Чингис хааны үйл амьдралыг харуулсан тайлбар толь бичиг (“Чингис хааны тухай товч толь” (1992), “Чингис хааны нэвтэрхий толь” (2005), “Монгол улсын шинжлэх ухаан” цувралаар гарсан “Чингис хаан” толь бичиг (2006) зэрэг) хэмээн ангилж болох юм.

Дээрх чиглэлүүдээр түүхч сонирхогч янз бүрийн хүмүүсийн бичсэн зохиол гарах болов. Тэдгээрээс хамгийн дорвитой нь С.Цэрэнбалтав, Ц.Минжин нарын “Тэмүжин-Чингис хааны намтар” I, II боть (2002, 2006) зохиол юм.

Чингис хааны мэндэлсний 840 жилийн ойд зориулан МУИС-ийн Түүхийн тэнхим “Үлэмжийн их Чингис хаан” сэдэвт Олон улсын эрдэм шинжилгээний

симпозиум, ШУА-ийн Түүхийн хүрээлэн эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулж, Чингис хааны дэлхий дахины болон Монголын түүхэнд гүйцэтгэсэн үүргийг шинээр авч үзсэн байна¹.

Чингис хааны тухай харийн эрдэмтдийн бүтээлийг монгол хэлнээ орчуулж буй нь Чингис судлал болон монголын түүхчдийн судалгаанд чухал нөхвөр болж байгааг тэмдэглэх хэрэгтэй юм. Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди 1999 оны XI сард захирамж гарган, Чингис хааны тухай гадаадын зохиолчдын туурвисан ном зохиолыг монгол хэлнээ орчуулж, нийтийн хүртээл болгохыг өөрийн дэргэд ажилладаг орон тооны бус "Түүхэн уламжлал, ёс заншлын салбар зөвлөл"-д үүрэг болгосон билээ. Ингээд "Чингис хаан" цуврал бий болгож, өнгөрсөн хугацаанд хорь шахам ном орчуулан хэвлүүлжээ. Тухайлбал, Мишель Хонгийн "Эзэн хаан Чингис" (2000), Е.И.Кычановын "Ертөнцийг эзэгнэн дагуулсан Тэмүжиний үйл амьдрал" (2000), Ш.И.Цыденжаповын "Богд Чингис хаан. Их Богд Эзэн Чингисийн нууцаас" (1991), Николай Горловын "Татаар нарын түүхэн шаштирууд, бусад баттай үнэн эх сурвалжуудаас авсан Чингис хааны бүрэн түүх оршивой" (2000), Вл. Череванскийн "Догшин давалгаат далай их Чингис хаан" (2000), С.С.Уолкерийн "Чингис хаан" (2001), Рене Груссегийн "Орлонг эзэгнэгч Чингис хаан" (2001), Гарольд Лэмбийн "Дэлхийн эзэн Чингис" (2003), Ялбак Халбай "Суут билиг төгс Богд эзэн Чингис" (2004), Артур Лунквисийн "Тэнгэрийн зарлигаар Чингис хааны үйл амьдралын зураглал" (2003), Н.Ц.Мункуевын "Монголын анхны хаадын тухай хятад эх сурвалж" (2004), В.Б.Папуевийн "Чингис хааны шар тугийн дор" (XII-XX зуун), (2004), Г.В.Вернадскийн "Чингисийн үеийн Монголчууд ба Орос улс" (2004), Михаэл Правдины "Чингис хаан, түүний өв удам" (2005) зэрэг бүтээлүүдийг хаалтанд дурьдсан онуудад их зонхийг орчуулагч Ч.Баатар орчуулж, доктор С.Одхүү эрхлэн гаргажээ. С.Одхүү "Чингис хааны амьдрал, үйл ажиллагаатай холбоотой ном зүйн тойм", "Монгол дахь Чингис судлалын товчоон" хэмээх ном гаргасан нь Чингис судлалд үр өгөөжтэй бүтээл болсон байна.

Өнөөгийн Монголын Чингис хаан судлалд дараах гол чиг хандлага ажиглагдаж байна. Үүнд:

1. Дэлхийн болон бүс нутгийн түүхэнд Чингис хааны гүйцэтгэсэн үүргийг сөргөөр тайлбарлаж ирснийг няцааж, эх сурвалж, судалгааны үндсэн дээр шинжлэх ухааны нэлээд бодитой гаргалгаа хийж буй,
2. Их хааны үйл ажиллагаа, сэтгэлгээний өвөөс улбаалан, гүн ухааны бодомж, эргэцүүлэл хийж байна.
3. Бүр хэтийдсэн хийсвэрлэл, дүгнэлт гаргаж, өөрийн үзэл бодлоо их хааны нэрээр илэрхийлэн, хүн төрөлхтнөөс хаацайлган ер бусын ид шидтэй мэтээр үзүүлэхийг оролдож буй явдал ч гарч байна. Ийм санаа түүх сонирхогчдын бичсэн зүйлд илүү хүчтэй ажиглагдаж буй. 1990-ээд оноос гадаадын түүхч, судлаач, нийтлэлчид Чингис хаан судлал руу хошуурах болов. Дэлхийн олон оронд гарсан Чингис хааны тухай бүтээлийг бүрэн шүүрдэн үзэх хэлний мэдлэг, билгийн цараа үл хүрэлцэх авч, олон улсад болон манай оронд түгэн дэлгэрсэн зарим гол бүтээлүүдийг хөндөн үзэж болох юм. Тухайлбал, Жек Ведерфордын "Чингис хаан" (Genghis Khan and the Making of the Modern World) (1993), Ким Жон Рэ-гийн "Мянган жилийн түүхэн хүн" (1999), Жорж Лейний "Чингис хаан ба Монголын жолоо" (Genghis Khan and Mongol Rule) (2004), Жон Мений "Хубилай хаан: Хятадыг төвшитгөсөн Монгол хаан" (Kublai Khan: The Mongol King Who Conquered China. 2006), Жү.Яотиний "Чингис хааны түүх шаштир" (2002) зэрэг бүтээлүүдийг дурьдаж

¹ Үлэмжийн их Чингис хаан. (Чингис хааны мэндэлсний 840 жилийн ойд зориулсан олон улсын эрдэмшинжилгээний хурлын материал) УБ.2002. Чингис хааны мэндэлсний 840 жилийн ойд зориулсан Эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлүүдийн эмхтгэл. УБ.2002

болох юм. Эдгээр бүтээлүүд их төлөв судалгаа-сурталчилгаа, нийтлэлийн шинжтэй боловч, тодорхой, тодорхой асуудлаар шинжлэх ухааны гаргалгаа, эрэгцүүлэл, бодомж дэвшүүлснээрээ үнэ цэнэтэй юм.

1990-ээд оноос хойш Чингис хаан судлал ийнхүү эрчимтэй хөгжсөнөөр судалгааны эл чиглэлд парадигмын шинжтэй өөрчлөлт гарав. Үүний үр дүнд Чингис хаан бол нэгдүгээрт, Монголын төрийн сэцэн билэгт гарамгай зүтгэлтэн, хоёрдугаарт, цэргийн суу билэгт, аугаа их жанжин, гуравдугаарт, Монгол үндэсний ялгуусан баатар, дөрөвдүгээрт, өнөөгийн ертөнцийг үндэслэгч гэдгийг дэлхий дахинд хүлээн зөвшөөрч байна. Хэдий тийм боловч Чингис хааны үйл ажиллагааны зарим талыг бүрэн дүүрэн судлаж, өмнөх үед тогтсон өрөөсгөл тахимгай ойлголтуудыг сурвалж, судалгааны үндсэн дээр залруулах шаардлага тулгарч байна. Нэг жишээ татахад Чингис хаан Дунд Ази руу байлдахдаа Нишапур, Херат зэрэг хотыг эзлэхдээ сая саяар нь алан хядсан мэтээр бичсэн байдаг. Гэтэл сая хүнтэй хот бий болсон түүхэн үе бол XX зууны эхэн үе шүү дээ. Ийм сүнсгүй залсан, хий хөөрөгдсөн тоо хэмжээ Чингис хааны тухай өмнөх судалгаанд маш их байдгийг зөв чиглэлд нь залруулах хэрэгтэй юм.

Сүүлийн үед Чингис хаан, түүнийг залгамжлагчдын талаар олон бүтээл гарч Чингис судлалыг урагш ахиулж буй боловч, бас хуудуутай зүйл багагүй тааралдсаар байгааг анхаарах хэрэгтэй юм. Тухайлбал, Жон Мен "Хубилай хаан" хэмээх бүтээлдээ: Тулуйтай шинэхэн гэрэлсэн Сорхогтани, түүнийг 7 жилийн хугацаагаар дайнд явсан эзгүй хойгуур нь Мөнх, Хубилай, Хүлэг, Ариг бөх гаргасан гэсэн хэт омтгой буруу дүгнэлт хийжээ. Түүнийхээр бол тэд бутачийн хүүхдүүд болж, монголын хаад алтан ургийн биш болж таарах нь ээ. Монголчуудын соёлыг өнгөц судалж гаргасан энгийн алдааны нэг нь гэхэд монгол хатадын богтого малгайг модоор хийсэн гэж бичсэн. Уг нь үйсээр хийсэн хөнгөн чанарын малгай юм. Энэ мэтээр алдаа мэдгийг нь сайтар магадалж байхгүй бол бид чинь гадны хүний бичсэн болгоныг адислан шүтээд баймааргүй санагдана.

Чингис хааныг Монголын хаан биш гэж булаацалдах явдал ч гарах болов. Ийм үзэл Казакстанд хүчтэй дэлгэрч байна. Тухайлбал, Петровын шинжлэх ухаан, соёлын академийн жинхэнэ гишүүн, математикийн ухааны доктор Хайрат Закирьянов энэ тухайд хэд, хэдэн газар томоохон ярилцлага өгчээ. Тэрбээр: Чингис хааны байгуулсан их улсын ойг "...юуны өмнө Астанд болох ёстой байсан юм. Дараа нь Казань, Анкар, Ташкент, Бишкект гэх мэтчилэн тэмдэглэх ёстой байлаа. Монголын гэж нэрлэгдээд байгаа 1206 онд байгуулагдсан улсын бүрэлдхүүнд өнөөдөр казакын ард түмнийг бүрдүүлж байгаа олон овог аймгууд багтаж байсан. Энэ улсыг казакын ард түмний гарамгай хүү Чингис хаан байгуулж өгсөн юм²" гэжээ. Ийм нөхцөлд Чингис судлалыг хөгжүүлэхийн тулд дав даруй дараах чиглэлээр ажиллах хэрэгтэй болов уу, Үүнд:

- Чингис хааны амьдрал, үйл ажиллагааг илтгэсэн сурвалжуудыг хятад, перс зэрэг олон хэлнээс орчуулан эмхтгэх,
- Чингис хааны тухай олон хэлээр гарсан ном, зохиолуудыг харьцуулан, түүх бичлэгийн бүтээл туурвих,
- Тодорхой төсөл боловсруулан, "Чингис хаан" их нэвтэрхий толь бэлтгэж, монгол, англи хэлнээ нийтлүүлэх,
- Чингис хааны үеийн удирдахуйн урлаг, менежмент, маркетинг зэрэг асуудлаар сурвалжид тулгуурлан гүнзгийрүүлсэн бүтээлүүдийг туурвих,

² Даяар Монгол. Америкийн Монголчуудын хэвлэл. 2007. I. 27. №116, 117

Ер нь сүүлийн 850 шахам жил дэлхий дахины түүхэнд гарамгай үүрэг гүйцэтгэсний хувьд нэг ч төрийн зүтгэлтэн Чингис хаан шиг судлаачид, зохиолч, сэтгүүлчдийн анхаарлыг татаж чадаагүй гэж бардаагаар хэлж болно.

Abstract: The article describes the progress achieved in Chinggis studies during and after the 1990s. In particular, as a result of these innovative trends Chinggis Khaan is revisited in Mongolian and world historiography as follows:

1. Chinggis Khaan was an outstanding statesman of Mongolia and a man of immense talent;
2. He was a great military commander known in the history of mankind;
3. He was a victorious national hero of Mongolia.